

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН ХАНГИ ХИЛИЙН БООМТЫН
ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФЫН ТОГТООЛЫН
ТӨСӨЛД САНАЛ АВЧ БАЙНА**

МОНГОЛ УЛСЫН ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2023 оны дүгээр
сарын -ны өдөр

Дугаар

Улаанбаатар хот

Тариф батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4, 9.2 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 67 дугаар зүйлийн 67.2 дахь хэсэг, “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК-ийн 2023 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн 01/494 дүгээр албан бичгийг тус тус үндэслэн Эрчим хүчний зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Дорноговь аймгийн Хатанбулаг сумын Ханги хилийн боомтын хэрэглэгчдэд борлуулах цахилгааны тарифыг хавсралтын ёсоор баталсугай.

2. Батлагдсан тарифыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэж, “Захиргааны хэм хэмжээний актын эмхтгэл”-д нийтлэгдсэн өдрөөс эхлэн мөрдөж ажиллахыг “Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ” ТӨХК (Н.Мөнгөнхөлөгт)-д үүрэг болгосугай.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын алба (Б.Болор-Эрдэнэ)-нд даалгасугай.

4. Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан Эрчим хүчний зохицуулах хорооны “Тариф батлах тухай” 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн 279 дүгээр тогтоолын хүчингүй болсонд тооцсугай.

ГАРЫН ҮСЭГ

Эрчим хүчний зохицуулах хорооны
2023 оны дугаар сарын -ны өдрийн
.... дугаар тогтоолын хавсралт

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ХАТАНБУЛАГ СУМЫН ХАНГИ ХИЛИЙН
БООМТЫН ХЭРЭГЛЭГЧДЭД БОРЛУУЛАХ ЦАХИЛГААНЫ ТАРИФ**

Үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага болон айл өрхөд борлуулах цахилгааны тарифыг (НӨАТ-гүй) ангиллаас нь хамааруулан төлбөр тооцох үзүүлэлтийн нэгжид дараах байдлаар тогтооно:

№	Ангилал	Хэмжих нэгж	Тариф
1	Уул уурхайн олборлох, боловсруулах аж үйлдвэр, зарим аж ахуйн нэгж байгууллага. Үүнд: <i>Нүүрс олборлолт, боловсруулалт Газрын тос, шатдаг хий олборлолт, боловсруулалт Төмрийн хүдэр олборлолт, боловсруулалт Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлолт Бусад ашигт малтмал олборлолт, боловсруулалт Банк, банкны нэгж Интернэт, үүрэн холбооны үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөл эзэмшигч Криптовалют олборлох, үйлдвэрлэх үйл ажиллагаа эрхлэгч</i>	Төг/кВт.ц	424.62
2	Бусад үйлдвэр, аж ахуйн нэгж байгууллага	Төг/кВт.ц	393.01
3	Айл өрх	Төг/кВт.ц	199.50